



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/02

Даланзадгад

“Эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн
ажиллах тухай

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дахь хэсэг болон Коронавируст /КОВИД-19/ халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас Өмнөговь аймгийн Нарийн сухайтын бүлэг орд газрыг “Ногоон бүс” болгох үүрэг чиглэл өгөгдсөний дагуу Шивээ хүрэн хилийн бүсэд ажиллаж байгаа тусгаарлан ажиглах байранд эмнэлгийн халдвар хамгааллын дэглэмийг бүрэн сахиулж, эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй явуулах, эмч мэргэжилтнийг томилон ажиллуулахыг Ноён сумын Сум дундын эмнэлэг /Ц.Бурмаа/-д үүрэг болгосугай.

2. Суурин болон хөдөлгөөнт хүн ам, хилийн боомтод эрүүл мэндийн анхан шатны болон яаралтай тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж ажиллах, тухайн сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн болон тээвэрлэлтийн компаниудын эмч, мэргэжилтнүүдэд халдвар хамгааллын чиглэлээр арга зүй, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллахыг Гурвантэс сумын эрүүл мэндийн төв /З.Оюунцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Коронавирус /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тусгаарлан ажиглах байранд хүн хүчийг дайчлан ажиллуулсан болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбогдон гарах санхүүгийн зардлыг тухай байгууллагын 2021 оны төсөвт багтаан шийдвэрлэж ажиллахыг Ноён сумын сум дундын эмнэлэг /Ц.Бурмаа/, Гурвантэс сумын эрүүл мэндийн төв /З.Оюунцэцэг/-д тус тус даалгасугай.

ДАРГА *Ц.Өнөр* Ц.ӨНӨРЖАРГАЛ



C:\ Desktop\2021 on TUSHAAL